



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 4/153

Хэрлэн сум

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх
арга хэмжээг зохион байгуулж,
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", 29.2, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.1, 5 дугаар зүйлийн 5.1, 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын нутаг дэвсгэрт байгаа мал амьтныг халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалт, угаалга, туулгалт, боловсруулалт, лабораторийн шинжилгээнд хамруулах, ариутгал халдваргүйжүүлэлт хийх зэрэг төлөвлөгөөт ажлыг орон нутаггаа графикт хугацаанд нь шуурхай зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2. Уг ажилд малчид, мал бүхий иргэд, орон нутгийн төр захиргааны байгууллагуудыг татан оролцуулах, ажиллах хүн хүч, тээврийн хэрэгслээр хангах, мал эмнэлгийн арга хэмжээнд мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийсэн болон малын гоц халдварт, халдварт өвчнийг нуун дарагдуулж заавар журмыг баримтлаагүйн улмаас өвчний тархалтыг нэмэгдүүлсэн малчин, мал бүхий иргэн, холбогдох албан тушаалтад хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг сумдын Засаг дарга, аймгийн Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/-т даалгасугай.

3. Малын гоц халдварт, халдварт өвчин гарах эрсдэл ихтэй байгааг харгалзан мал, амьтны шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулах, мал амьтны хашаа, байр, бэлчээр болон мал аж ахуйн гаралтай түүхий эд хүнсний бүтээгдэхүүнээр худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлдэг газруудыг халдваргүйтгэх ажлыг мал эмнэлгийн байгууллагаар гүйцэтгүүлсүгэй.

4. Аймгийн нутаг дэвсгэрт мал амьтны халдварт, паразиттах өвчнөөс


01 718

урьдчилан сэргийлэх, эмчлэх, тандалт шинжилгээ, оношлогоо, халдваргүйжүүлэлт хийх арга хэмжээг графикт хугацаанд нь зохион байгуулж, шаардагдах эм бэлдмэл, вакцин, эм урвалжийг хугацаанд нь хүргэн мэргэжлийн удирдлагаар хангаж, ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Хүнс, Хөдөө аж ахуйн газар /Ж.Энх-Амгалан/-т үүрэг болгосугай.

5. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ, тандалт оношлогоо, шинжилгээ, халдваргүйжүүлэлтийн явц гүйцэтгэлд хяналт, шалгалт хийхэд шаардагдах зардлыг аймгийн төсөвт батлагдсан мал эмнэлгийн тарилгын үйлчилгээний хөлсний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т зөвшөөрсүгэй.

6. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Э.Мөнх-Эрдэнэ/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА